



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/457

Хэрлэн сум

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээ”-ний тухай журам, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хорин гуравдугаар хуралдааны 05 дугаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Долоодугаар хуралдааны 2025 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 1 нэрийн 23,300,000 (хорин гурван сая гурван зуун мянга) төгрөгийн балансын үнэтэй, 23,300,000 (хорин гурван сая гурван зуун мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, үлдэх өртөггүй тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Д.Билгээ

Орон нутгийн өмчийн газрын дарга

Хөтлөгч:

Л.Рэгзэдмаа

Орон нутгийн өмчийн газрын
Ашиглалт, зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Л.Отгончимэг

Орон нутгийн өмчийн газрын
Удирдлага, хяналт хариуцсан
мэргэжилтэн

3.Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 11 цагт аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн байрны 1 давхарт Орон нутгийн өмчийн газрын өрөөнд зохион байгуулсугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ





۱۴۹

فہرست مضامین:

Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт

№	Эзэмшигч байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн, орж ирсэн огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Байгууллагын үнийн санал	ОНӨГ-ын санал	АИТХ-ын шийдвэр
1	Нэгдсэн эмнэлэг	УАЗ-469	43-30 ХЭҮ	2013/2013	1	23,300,000	23,300,000	-	1,000,000	1,000,000	1,000,000
						23,300,000	23,300,000				

2025 оны 08 дугаар сарын 22-ны
АИТХ-ын дугаар захирамжийн хэвсрэлт

Аймгийн Засаг даргын
А.Н.Сүхбаатар